

“ХОТЖИЛТ БА ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2018 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Өмнөговь аймаг Эрүүл мэндийн газар

2018он

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
1.	Төсөл хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар: Засгийн газрын 2015 оны 4 дүгээр тогтоолын хавсралт	Хөтөлбөрийн зорилго: Иргэд, хамт олон, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаанд тулгуурлан хот, суурин газрын оршин суугчдын эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хотжилтоос хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв
3.	Хэрэгжүүлэгч байгууллага /хэрэгжих нийт хугацаа: 2016-2020 он	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: НЭМА, Улсын байцаагч, ЭМТ, Байгал хамгаалагч, Эрүүл Мэндийн Салбар Зөвлөл, Сүрьеэ диспансар, ЭМТөвүүд (Багийн эмч нар, Дүн бүртгэгч) Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ААН байгууллага, СЗДТГ, Ард иргэд, Багийн дарга нар
4.	Хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1: Хотжилтоос үүдэлтэй хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн бодлогын дэмжлэгт орчинг бүрдүүлэх. Зорилт 2: Хотжилтоос үүдэлтэй сөрөг нөлөөллийн эрүүл мэндийн тандалтын тогтолцоог бий болгох Зорилт 3. Хот, суурин газрын оршин суугчдын аюулгүй байдал, таатай орчин, эрүүл ахуйн нөхцөлийг айжруулах. Зорилт 4. Хот, суурин газрын оршин суугчдын эрүүл аж төрөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хотын амьдрал, болон хотын соёлын талаарх мэдлэг, хандалгыг дээшлүүлэх Зорилт 5. Хот, суурин газрын оршин суугчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах.
5.	Төсөв (нийт шаардагдах,	

	Зардал	зардал)								
		Үүнд:	Төсөв (он)			Гүйцэтгэл			Хувь	
		Багц 1								
		Багц 2								
6.	Хөтөлбөрийн зорилт		Биелэлт							
	1-р зорилтын хүрээнд Хотжилтоос үүдэлтэй хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн бодлогын дэмжлэгт орчинг бүрдүүлэх.		<p>1.1 Айл өрх, албан байгууллагад ариун цэвэр, эрүүл ахуйн талаар мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан ба давхардсан тоогоор 7148 иргэн хамрагдсан байна.</p> <p>1.2 Сумын эрүүл мэндийн байгууллагууд иргэдэд зориулж “Ундны усны эрүүл ахуйн” талаар мэдээллийн самбар гаргаж, ус зөөх, хадгалах сав болон бусад ундны устай холбоотой мэдээллээр хангаж байна.</p> <p>1.3 Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой шилжиж явсан ба ирсэн иргэдийн тоог гарган, шилжин ирж суурьшсан иргэдийг бүртгэн, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж ажиллаж байна.</p> <p>1.4 Албан байгууллагууд гаднах талбайн тохижилтыг сайжруулах зорилгоор аймгийн хэмжээнд 6590 гаруй 5-н төрлийн мод суулгаад байна.</p>							
	2-р зорилтын хүрээнд Хотжилтоос үүдэлтэй сөрөг нөлөөллийн эрүүл мэндийн тандалтын тогтолцоог бий болгох		2.1 Сум бүр тогтмол хугацаанд гадна орчны их цэвэрлэгээ хийж дадсан ба сумдууд хогын төвлөрсөн цэгийг сайжруулах арга хэмжээ авч ажилласан.							
	3-р зорилтын хүрээнд Хот, суурин газрын оршин суугчдын аюулгүй байдал, таатай орчин, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах.		<p>3.1 Нийт 1530 иргэнд ундны ус хадгалах, зөөх савны талаар зөвлөгөө өгсөн ба эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усны савны талаарх судалгаа хийсэн сумдын судалгааны үр дүнгээс үзэхэд Ханхонгор сумын 128 өрхөөс 43,75% нь, Ханбогд сумын 40 өрхөөс 30% нь, Цогт-овоо сумын 65 өрхөөс 13% нь стандартын шаардлага хангасан ус хадгалах савтай байна.</p> <p>3.2 Эрүүл аюулгүй, цэвэр орчныг бий болгох хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх зорилгоор иргэдэд сургалт зохион байгуулсан ба 1810 иргэн хамрагдсан.</p> <p>3.3 Гурвантэс сум Аюулгүй орчин бүрдүүлэх ажлын хүрээнд “Миний ажлын байр-Аюулгүй орчин” аян</p>							

		зарлаж төрийн болон төрийн бус 9 байгууллага, “Миний анги-Аюулгүй орчин” аяны хүрээнд цэцэрлэгийн 312, ЕБС-ийн 470 сурагч, “Миний гэр-Аюулгүй орчин” аяны хүрээнд 330 багш, эцэг эхчүүдийг хамруулж нийт 870ширхэг гарын авлага тарааж, аюулгүй орчны талаар сургалт хийж, аюулгүй орчин бий болгох тохижилтын олон үйл ажиллагаа зохиосон байна.
	4-р зорилтын хүрээнд Хот, суурин газрын оршин суугчдын эрүүл аж төрөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хотын амьдрал, болон хотын соёлын талаарх мэдлэг, хандалгыг дээшлүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	4.1 Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулсан эрүүл мэндийн сургалт сурталчилгааг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай нь хамтран зохион байгуулсан ба 5564 хүүхэд, эцэг эхчүүд хамрагдсан. 4.2 Гурвантэс сумын НЭМ-ийн мэргэжилтэн Г.Хонгорзул ЕБС-ын ахлах ангийн 50 хүүхдээс тамхины хэрэглээний талаар судалгаа авсан. Тамхи татдаг 3, тамхи татаж үзсэн 19, огт үзээгүй 28 сурагч байсан ба энэхүү судалгааны дүн дээр үндэслэн ахлах ангийнханд өртөөчилсөн байдлаар сургалтыг зохион байгуулсан. Мөн сурагчдын дунд гар зураг, зохион бичлэг бусад тэмцээн уралдаан зарлагдсан бөгөөд 568 сурагч оролцож дам тамхидалт болон тамхины хор нөлөөний талаар мэдлэгтэй болсон.
	5-р зорилтын хүрээнд Хот, суурин газрын оршин суугчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах.	5.1 Малчдад болон гэрээр асаргаатай байгаа өндөр настангуудад гэрт очиж эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн ба нийт 2000 гаруй иргэн хамрагдсан байна.
7.	Дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/	Ололттой тал- Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд ЭМБ бүр оролцож мод тарисан. Дутагдалтай тал- Энэхүү хөтөлбөрийг орон нутгийн байгууллагууд өөрсдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөгөө болгож ажиллаж чадахгүй, хот суурин газарт хэрэгжих үйл ажиллагаа талаас нь харж байгаа тул хэрэгжилт хангалттай сайн байж чадахгүй байна. Анхаарах асуудлууд- Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бусад салбар байгууллагын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.
8.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	

9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
		80%	5	85%	70%	90%	80%	75%
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ						

Орчны эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн: У.Үүрийнтуяа